

ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ

Гаалийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллагуудын 2024 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны үр дүнд “Гаалийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх аргачлал”-ын дагуу хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлангаас мэдээлэв.

ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙН НЭГЖ, ДЭРГЭДЭХ БАЙГУУЛЛАГУУДЫН ҮНЭЛГЭЭ

Гаалийн ерөнхий газрын 25 зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллагын 2024 оны эхний хагас жилийн үйл ажиллагааг шинэчлэн баталсан нийт 285 шалгуур үзүүлэлтийн биелэлтийн дундаж үнэлгээ **86.7** оноотой “**В**” буюу “**Сайн**” үнэлгээтэй байна.

Хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн үр дүнгээр сүүлийн хагас жилийн гүйцэтгэлийг сайжруулах зорилгоор нийтлэг болон тусгайлсан 92 зөвлөмж хүргүүлэв.

Д/д	Эрэмбэ	Нэрс	Дүн
1	ГАЗАР	Захиргааны удирдлагын газар	89.5
2		Хяналт, бүрдүүлэлтийн газар	86.7
3		Татвар орлогын газар	85.7
4		Зөрчилтэй тэмцэх газар	88.1
5		Санхүү, хөрөнгө оруулалтын газар	88.4
6		Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар	89.1
7	ХЭЛТЭС	Дотоод хяналт, аюулгүй байдлын хэлтэс	85.0
8		Хүний нөөцийн хэлтэс	89.7
9		Хуулийн хэлтэс	86.6
10		Гадаад хамтын ажиллагааны хэлтэс	85.7
11		Эрсдэлийн удирдлагын хэлтэс	92.7
12		Хорио цээрийн хэлтэс	81.8
13		Барааны ангилал, үнэлгээний хэлтэс	89.7
14		Статистик, дүн шинжилгээний хэлтэс	87.9
15		Хар тамхи, мөнгө угаахтай тэмцэх хэлтэс	81.8
16		Боомтын хэлтэс	86.2
17	ДЭРГЭДЭХ БАЙГУУЛЛАГА	Сургалтын төв	83.2
18		Олон нийттэй харилцах төв	89.2
19		Аж ахуй, үйлчилгээний алба	87.6
20		Шуурхай хяналтын төв	86.3
21		Бүрдүүлэлтийн дараах шалгалтын газар	84.2
22		Мэдээллийн технологийн газар	80.8
23		Эрэлч нохойн сургалтын төв	89.4
24		Гаалийн төв лаборатори	83.3
25		Бүрдүүлэлтийн цахим төв	89.3
Дундаж үнэлгээ			86.7

НИЙТЛЭГ ЗӨВЛӨМЖӨӨС:

1. Гаалийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллага тус бүр “Гаалийн байгууллагын 2021-2024 оны стратеги төлөвлөгөө”-ний арга хэмжээнээс чиг үүргийн хүрээний хоцрогдолтой буюу гүйцэтгэл 30-70 хувийн үнэлгээтэй 14 арга хэмжээний хэрэгжилтэд онцгой анхаарах;
2. Олон нэгж хамтран хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр арга хэмжээний биелэлтийг тайлагнаж ирүүлэхгүй орхигдуулах тохиолдолд гарч байгаад анхаарч, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд хэрэгжүүлж буй арга хэмжээний уялдааг хангаж тайлагнах;
3. Тайлант хугацаанд нэгжүүдээс ГЕГ-ын дарга, Дэд даргаар батлуулсан цаг үеийн шинжтэй аливаа төлөвлөгөөт арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг тухай бүр ирүүлж, үр дүнд нь хяналт шинжилгээ, үнэлгээ хийлгэж хэвших;
4. ГЕГ-ын ЗББНДБ-уудаас харьяа гаалийн газар, хороодод ЗДАС-ийн “Үүрэг даалгавар”-ын программаар өгч буй үүрэг даалгаврын биелэлтийг хугацаандаа оруулж буй эсэхэд тогтмол хяналт тавьж, бодитой үнэлэх, биелэлт хангалтгүй тохиолдолд биелэгдэх хүртэл нь дахин өгч хяналт тавьж ажиллах;
5. Бодлогын бичиг баримт, хууль тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилтийн үр дүнг үнэлүүлэхтэй холбоотой мэдээ, тайланг Захиргааны удирдлагын газар, Хуулийн хэлтэст хугацаанд нь үнэн зөв гаргаж өгөх, дутуу, буруу тайлагнахгүй байхад анхаарах;
6. Дээрх хэрэгжилтийг тайлагнахын тулд ГЕГ-ын ЗББНДБ-ууд өөрийн чиг үүрэгт хамаарах эрх зүйн актын жагсаалтыг Хуулийн хэлтэстэй хамтран бие даан болон хамтран хэрэгжүүлэх нэгж зэрэг байдлаар төрөлжүүлж ангилсны дагуу хэрэгжилтийг гаргаж хэвших;

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

2024.07.22

